



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР**

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай 1,  
Төрийн ордон, Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: secretariat@parliament.mn  
http://www.parliament.mn

2014. 04. 09 № 14/589

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Төлөвлөгөөний биелэлт хүргүүлэх  
тухай**


Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны 2013 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн хуралдааны тэмдэглэлээр тус Тамгын газарт тодорхой ажлуудыг гүйцэтгэх үүрэг өгсөн билээ.

Энэ хугацаанд Улсын Их Хурлын Тамгын газар нь Төрийн байгуулалтын байнгын хорооноос өгсөн үүргийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргаж ажилласан бөгөөд төлөвлөгөөний биелэлтийг Танд хүргүүлж байна.

Хавсралт 4 хуудастай.

Хүндэтгэсэн,

**ЕРӨНХИЙ НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА**



**Б.БОЛДБААТАР**

0000001339

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ 2013 ОНЫ 10 ДУГААР САРЫН 15-НЫ  
ӨДРИЙН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭР УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАРТ ӨГСӨН ҮҮРГИЙГ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

**2014.04.03**

№	Өгсөн үүргийн чиглэл	Авах арга хэмжээ	Хугацаа	Хариуцах хэлтэс, алба, ажилтан	Биелэлт
<b>Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хэлэцэхэд үзүүлэх мэргэжлийн туслалцаа</b>					
1	УИХ-аар хэлэлцэгдэх хууль, бусад шийдвэрийн төсөлтэй холбогдсон хууль, эрх зүй, судалгаа мэдээлэл, лавлагааны үйлчилгээг сайжруулах, УИХ-ын гишүүдийг судалгаа, мэдээллээр ханган ажиллах, бодлогын судалгааг бусад судалгааны байгууллага, судлаачдаар гүйцэтгүүлэх журам боловсруулж батлуулах	УИХ-ын гишүүдийг судалгаа, мэдээллээр ханган ажиллах, бодлогын судалгааг бусад судалгааны байгууллага, судлаачдаар гүйцэтгүүлэх журам боловсруулж батлуулах	2013.11.10	Судалгаа, шинжилгээний хэлтэс Ц.Норовдондог	“Улсын Их Хурлын захиалгаар бодлогын судалгаа, шинжилгээний ажил гүйцэтгүүлэх журам”-ыг боловсруулж, Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөлөөр хэлэлцүүлж батлуулахаар өгсөн.
2	УИХ-ын гишүүдээс хянан шалгах чиг үүргээ хэрэгжүүлэх, шийдвэрийн биелэлтийг хангахад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, төсвийн шинжилгээний үйл ажиллагааг шинэ шатанд гаргах	“Хууль, УИХ-ын бусад шийдвэрийн хэрэгжилт, дүн мэдээг нэгтгэх, хэрэгжилтийг мэдээлэх журам”-ын төсөл боловсруулж батлуулах	2013.11.22	Хяналт, үнэлгээний хэлтсийн дарга Л.Энхтуяа	Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн хэрэгжилт, дүн мэдээг нэгтгэх, хэрэгжилтийг мэдээлэх журам”-ыг боловсруулж, удирдлагын түвшинд танилцуулаад байна.
		Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, яамд, УИХ-аас томилогддог байгууллагуудын дунд “Монгол Улсын хууль тогтоомжийн хэрэгжилтийн өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага” сэдэвт сургалт зохион байгуулах	2013.11.26	Хяналт, үнэлгээний хэлтсийн дарга Л.Энхтуяа	Сургалт зохион байгуулахтай холбоотойгоор ажлын төлөвлөгөө боловсруулан Тамгын газрын Нарийн бичгийн даргаар батлуулан ажиллаж байна. Хэрэгжилт удаашралтай байгаа 21 хуулийг сонгон судалгааг хийх явцад 6 яамдын удирдлагууд болон хуулийн хэрэгжилт хариуцсан ажилтнууд оролцсон ярилцлага зохион байгуулсан. Засгийн газраас 2013 оны жилийн эцсийн хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаарх мэдээ ирээгүй байгаагаас хэлэлцүүлэг зохион байгуулах хугацаа хойшилсон.
		Төсвийн албаны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг УИХ-аар хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах	2013.11.25	Хяналт, үнэлгээний хэлтсийн дарга Л.Энхтуяа	Төсвийн байнгын хорооны 2013 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, төслийг УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх нь зүйтэй гэж шийдвэрлэсний дагуу 10 дугаар сарын 31-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, дараагийн хэлэлцүүлэгт



					бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн. Төсвийн байнгын хорооноос Төрийн байгуулалтын байнгын хороотой хамтран ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.
		УИХ-д өргөн барьсан хууль, бусад шийдвэрийн төсөлд зардлын тооцоо, дүн шинжилгээ хийх тухай журам	2013 оны 12 сар	Хяналт, үнэлгээн-ий хэлтсийн дарга Л.Энхтуяа	Төсвийн шинжилгээ, дүгнэлт хийх журмын төслийг боловсруулж, удирдлагад танилцуулаад байна.
3	Хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төслийг хэлэлцэх үед холбогдох салбарын мэргэжилтэн, төрийн болон төрийн бус байгууллага, олон нийтийн саналыг тусгаж ажиллахад анхаарах	Байнгын хорооноос холбогдох хууль, УИХ-ын бусад шийдвэрийн талаар нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулах, өргөн баригдсан болон чуулганаар хэлэлцэж буй хуулийн төслийг УИХ-ын вэб хуудсаар болон боломжит бусад хэлбэрээр тавьж, иргэд, байгууллагын саналыг авах, төсөлд тусгах ажлыг сайжруулах	Тухай бүр	Хууль зүйн үйлчилгээний хэлтэс, Байнгын хорооны ажлын алба	Байнгын хорооноос холбогдох хууль, УИХ-ын бусад шийдвэрийн талаар нээлттэй хэлэлцүүлгийг 7 удаа зохион байгуулж, зарим өргөн баригдсан болон чуулганаар хэлэлцэж буй хуулийн төсөлтэй холбогдуулан санал, асуулга авч хэлэлцүүлэн төсөлд тусгасан.
		Иргэдээс УИХ-ын цахим хуудсаар дамжуулан хуулийн төслийн талаар ирүүлсэн саналыг нэгтгэн интранетийн системд харуулах нэмэлт модулийг программчлах	2013.12.31	Мэдээллийн технологийн хэлтсийн дарга Ж.Элбэгзаяа	Иргэдээс УИХ-ын цахим хуудсаар дамжуулан хуулийн төслийн талаар ирүүлсэн саналыг нэгтгэн интранетийн системд харуулах нэмэлт модулийг программчилж интранетээс хариу өгөх боломжтой болсон.
		Нээлттэй хэлэлцүүлгийн танхим тохижуулах	2013-2014 онд	Мэдээллийн технологийн хэлтсийн дарга Ж.Элбэгзаяа	Нээлттэй хэлэлцүүлгийн танхимд шаардлагатай бүх техник хэрэгслийг бэлэн болгосон. Архивын фондын өрөөний шилжилт хөдөлгөөнөөс шалтгаалан суурилуулалтын ажил хүлээгдэж байна.
4	УИХ-ын хууль тогтоох үйл ажиллагааг тасралтгүй, түргэн шуурхай, үр дүнтэй явуулах нөхцөлийг бүрдүүлэх, Байнгын хорооны бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр холбогдох хууль, УИХ-ын Тамгын газрын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулж шийдвэрлүүлэх	Улсын Их Хурлын тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн зөрчилтэй зүйл, заалтын жагсаалт гаргаж, тухайн хуулиудад өөрчлөлт оруулах саналыг Байнгын хороо, ажлын хэсэгт хүргүүлэх	Тухай бүр	Хууль зүйн үйлчилгээ хариуцсан нарийн бичгийн дарга Н.Отгончимэг	Улсын Их Хурлын тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай өргөн мэдүүлсэн буюу хэлэлцүүлгийн шатанд байгаа хуулийн төслүүдийг нэгтгэн боловсруулж, эдгээр хуулийн зарим зөрчилтэй нарийвчлан тусгах заалтын саналаа нэгтгэн Төрийн байгуулалтын байнгын хороонд өгсөн. Эдгээр нэмэлт, өөрчлөлтийн талаар нам, эвслийн бүлгээс санал авах ажил хийгдэж байна.
<b>Улсын Их Хурлын хэвлэл мэдээлэл, сурталчилгааны үйл ажиллагаа</b>					
5	Улсын Их Хурлын үйл ажиллагааг сурталчлах төвүүдийн эрх зүйн байдал, чиг үүргийг тодорхой болгож, үйл ажиллагааг нь жигдрүүлэх арга хэмжээ авах	Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөрийн төсөлтэй хамтран олон нийттэй харилцах стратеги боловсруулах	2013.12 сард	Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийн дарга О.Батханд	Улсын Их Хурлын үйл ажиллагааг сурталчлах төвүүдийн эрх зүйн байдал, чиг үүргийг тодорхой болгож, үйл ажиллагааг нь жигдрүүлэх арга хэмжээ авах ажлын хүрээнд НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн



					төсөлтэй хамтран боловсруулж байгаа олон нийттэй харилцах стратегийн төслийн ажлын судалгааны болон стратегийн төслийн эхний шатны тайлантай хэлтсийн холбогдох ажилтнууд танилцан боловсронгуй болгох талаар санал, дүгнэлтээ бичгээр гаргаж өгсөн. Цаашид стратегийн төслийг хүлээн авсны дараа олон нийттэй харилцах үйл ажиллагаанд баримтлан ажиллахаар төлөвлөж байна.
	УИХ-ын үйл ажиллагааг сурталчлах төвийн жишиг загварыг гаргах, УИХ-ын үйл ажиллагааг сурталчлах төвүүдийг хөгжүүлэх	Төслийн хугацаанд	Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийн дарга О.Батханд	Улсын Их Хурлыг сурталчлах төвүүдийг цаашид аймгуудын Иргэдийн төлөөлөгчдийн хуралд хариуцуулан ажиллуулахаар болж, хариуцсан ажилтнуудыг жилд хоёр удаа сургалтад хамруулах төлөвлөгөөг гарган эхний сургалтыг зохион байгуулахаар бэлтгэлийг ханган ажиллаж байна. Дархан-Уул, Дорнод, Сэлэнгэ, Завхан, Өмнөговь, Сүхбаатар, Баян-Өлгий, Ховд аймгийн Улсын Их Хурлыг сурталчлах төвд мэдээллийн цахим самбарыг хүргүүлэхээр шийдвэрлэсэн. Түүнчлэн "Улсын Их Хурлын 2013 оны намрын ээлжит чуулганы үйл ажиллагааны танилцуулга", "Парламентын тухай 100 асуулт", "Үндсэн хуулиа дээдлэхүй" зэрэг 30 нэр төрлийн 1708 номыг 9 дүүрэг, 21 аймгийн Улсын Их Хурлыг сурталчлах төвүүдэд хүргүүлэн ажиллалаа.	
6	Улсын Их Хурлаас баталсан хууль болон бусад шийдвэрүүдийг нийтэлдэг "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийг төр захиргааны болон холбогдох байгууллагуудад шуурхай, үнэ төлбөргүй хүргэх ажлыг зохион байгуулах	"Төрийн мэдээлэл" эмхэтгэлийг үнэ төлбөргүй хүргэх ажлыг зохион байгуулах	2014.01.01	Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийн дарга О.Батханд, Захиргаа, нийтлэг үйлчилгээний хэлтсийн дарга Н.Ширэндэв	"Төрийн мэдээлэл" эмхэтгэлийг 2014 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс үнэ төлбөргүй хүргэх ажлыг эхлүүллээ. Нийт 70 гаруй байгууллагад 5438 ширхэг эмхэтгэлийг үнэ төлбөргүй хүргэж байгаа бөгөөд иргэд, аж ахуйн нэгжүүд, гадаадын байгууллагаас "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийг захиалан авах хүсэлт ирүүлсний дагуу Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын захирамж гарч, II улиралд 1734 байгууллагад хүргэсэн. Нийт 7172 ширхэг "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийг үнэ төлбөргүйгээр болон захиалгын дагуу уншигчдад хүргээд байна.
<b>Зохион байгуулалтын үйл ажиллагаа</b>					

7.	УИХ-ын Тамгын газрын нэгжүүд, УИХ дахь нам, эвслийн бүлгүүд, УИХ-ын гишүүдийн зөвлөх, туслахуудын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах	УИХ-ын нэгдсэн хуралдаан, Байнгын хороо, дэд хороодын хуралдааны ирц бүрдүүлэхэд нам, эвслийн бүлэг, гишүүний зөвлөх, туслахуудтай хамтран ажиллах талаар "Нэгдсэн болон Байнгын хорооны хуралдаан зохион байгуулах тухай" журамд нэмэлт өөрчлөлт оруулах	2013 онд	Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Цогтсайхан	УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын 2013 оны 662 дугаар захирамжаар "УИХ-ын чуулганы хуралдааны бэлтгэл, зохион байгуулалтыг хангах журам"-ыг баталж, мөрдүүлэн ажиллаж байна.
		Тамгын газрын хэлтэс, албадын хэрэгжүүлж байгаа ажил, тэдгээрийн уялдаа холбоог сайжруулах талаар мэдээлэл-хэлэлцүүлэг хийх	2013 оны 12 сард	Нийт хэлтэс	УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын 2014 оны 49 дүгээр захирамжаар хэлтсүүдийн үйл ажиллагааны үр дүнг сонсох хуваарийг батлан, Ерөнхий нарийн бичгийн даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж байна.
<b>Тамгын газрын хүний нөөц, боловсон хүчний чадавхыг бэхжүүлэх үйл ажиллагаа</b>					
8	УИХ-ын Тамгын газрыг мэргэжлийн өндөр түвшинд бэлтгэгдсэн, чадварлаг боловсон хүчнээр хангах, тэдгээрийг тогтвор суурьшилтай ажиллуулах нөхцөл бололцоогоор хангах талаар санал боловсруулж шийдвэрлүүлэх	УИХ-ын Тамгын газрын ажилтнуудын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх	2013 оны 12 -р сард	Захиргаа, нийтлэг үйлчилгээний хэлтсийн дарга Н.Ширэндэв	УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын 2013 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 707 дугаар захирамжаар "УИХ-ын Тамгын газрын ажилтнуудын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр"-ийг баталж, мөрдүүлэн ажиллаж байна.
9	УИХ-ын Тамгын газрын ажилтнуудын ажлыг дүгнэх, урамшуулах, хариуцлага тооцох дүрэм, журмыг тодорхой болгох, тэдний мэргэжлийн үр чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх сургалтуудыг тогтмол зохион байгуулах	Тамгын газрын хүний нөөцийг бэхжүүлэх сургалтын хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх	2013 оны 12 -р сард	Захиргаа, нийтлэг үйлчилгээний хэлтсийн дарга Н.Ширэндэв	УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын 2013 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 687 дугаар захирамжаар "УИХ-ын Тамгын газрын хүний нөөцийг бэхжүүлэх сургалтын хөтөлбөр"-ийг батлан хэрэгжүүлж байна.
		Тамгын газрын 2014 оны сургалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулах	2013 оны 12 -р сард	Захиргаа, нийтлэг үйлчилгээний хэлтсийн дарга Н.Ширэндэв	УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын 2014 оны 55 дугаар захирамжаар "Тамгын газрын 2014 оны сургалтын ерөнхий төлөвлөгөө"-г батлан хэрэгжүүлж байна.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР